

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2018 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ
/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ/**

2018.03.30

Улаанбаатар хот

ЗГҮАХ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	2018 он		Хэрэгжилт	Үнэлгээ
					Хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв, (сая төгрөг)		
Тэргүүлэх зорилт № 2.1. Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.								
1	2.11. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана	2. “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх	-	-	Гадаадын хөрөнгө оруулалтыг татах үндсэн нөхцөл бүрдэх	-	<p>БТГ, АТБХЗГ: 2017 онд: Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах чиглэлээр судалгаа хийж зураглал гарган, ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар байгуулсан. Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгааны ажлыг 2017 онд 25.0 сая төгрөгөөр хийхээр зам, тээврийн салбарын норм нормативыг боловсронгуй болгох сангийн 2017-2018 оны төлөвлөгөөнд тусгасан. Уг ажлын хүрээнд ачаа тээврийн хэмжээ, хэтийн төлөвийг судлан, ачаа үүсэх, шингээх гол цэгүүдийг тодорхойлон, замын сүлжээтэй уялдуулан тээвэр логистикийн төвүүдийн байршлыг тодорхойлох ажлыг хийхээр төлөвлөсөн.</p> <p>Худалдаа-Эдийн засаг, Шинжлэх ухаан-Техникийн Хамтын Ажиллагааны Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Тээврийн ажлын хэсгийн 13-р хуралдаанаар “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг тавьсан боловч тодорхой шийдвэрт хүрч чадаагүй болно.</p> <p>“Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа”-ны ажлын даалгаварт 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг тусгаж, 2017 оны 06 дугаар сард ТНБД-аар батлуулж, мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгэх зөвлөх үйлчилгээ авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт хийсэн.</p> <p>“Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа”-ны Зөвлөх үйлчилгээний тендерт “Монголын логистикийн холбоо” ТББ шалгарч, 2017 оны 267 дугаар гэрээг байгуулсан. Энэхүү зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд “Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа” гэрээт ажлын эхлэлийн тайлан болон судалгааны ажлын дундын тайланг ирүүлээд байна. Уг судалгааны ажлын дундын тайланд</p>	40%

								ажлын даалгаварт заагдсан ажлуудыг бүрэн хийлгэх саналыг гүйцэтгэгчид хүргүүлээд байна.	
Тэргүүлэх зорилт №2.6. Эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аюулгүй, ая тухтай үйлчилгээ үзүүлэх зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.									
2	2.107. Олон улс, хот хоорондын болон орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хэсгийг үргэлжлүүлнэ	1. Ховд-Өлгий-Улаанбайшин т чиглэлийн 189.7 км хатуу хучилттай авто замыг барих	2016 - 2018	Улсын төсөв, гадаад эх үүсвэр	114 300,0	Барилгын ажлыг дуусгах	57 150,0 2017 онд зарцуулсан 50 681,02	АЗБХЗГ: 2017 онд: “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд АХБ-ны 3129-МОН зээлийн хөрөнгөөр хэрэгжих Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км авто замын барилгын ажлыг 4 багц хэсгээр зохион байгуулан хэрэгжүүлж байна. Зам барилгын ажлын гэрээг багц тус бүрээр 2015 оны 08 дугаар сард байгуулсан. Багц 1, 2, 3 хэсгийн барилгын ажил 2016 оны 05 дугаар сард эхэлсэн. Гэрээний дагуу дээрх багц хэсгүүдийн барилгын ажлыг 2018 оны 08 дугаар сарын 30-нд дуусгаж ашиглалтад оруулна. Зам барилгын ажлын хэрэгжилтийн хувийг авч үзвэл нийт барилгын ажил 47.5%-тай. 2018 онд: Барилгын ажлыг эхлүүлэхэд шаадлагатай бэлтгэл ажлыг хангах хүрээнд гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрлийг 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Мөн барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг гарган батлуулсан.	40%
3		2. Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км хатуу хучилттай авто замыг барих	2018-2020	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	220,000.0	Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь	44,000.0	Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан. Уг тогтоолын дагуу Үндэсний хөгжлийн газраас 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдөр “Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл”-ийн концесс олгох 2 үе шаттай уралдаант шалгаруулалтыг зарласан. Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 11.00 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд тус төсөлд 1 оролцогч санал ирүүлсэн бөгөөд комисс уг оролцогчийн саналыг үнэлж, дараагийн үе шат болох уралдаант шалгаруулалтад оруулахаар шийдвэрлэсэн. Комиссоос уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулан тус оролцогчид 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баримт бичгийг олгож	40%

								эхэлсэн бөгөөд төслийн саналыг 2018 оны 04 дугаар сарын 19-ний өдрийн 11.00 цагаас өмнө хүлээн авна.	
4		3. Өгийнуур-Батцэнгэл-Их Тамир чиглэлийн 130.6 км хатуу хучилттай авто замыг барих	2018-2020	Төр, хувийн хэвшлийн түншлэл	57,200.0	Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь	11,440.0	Уг төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. 2017.05.08-ны өдрийн 01/1968 тоот албан бичгээр тус замын "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т тусгуулах санал Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.	-
5		4.Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.5 км хатуу хучилттай авто замыг барих	2016-2018	Гадаад зээл	86 100,0	Барилгын ажлыг дуусгах	2017 онд зарцуулсан 60 270,0 37 478,6	АЗБХЗГ: 2017 онд: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Шанхай Констракшн Групп" компани шалгарч 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нийт 56,785,696.10 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд 2017 онд авто замын барилгын ажлыг 47.68 хувьд хүргэнэ. Нийт ажлын явц 39.2%-тай байна. 8.48%-ийн хоцролттой. 2018 онд: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 350 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.03.14-ний өдрийн 72 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. 2-р улиралд батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.01-ний өдөр эхлүүлнэ.	40%
6		5.Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замыг барих	2017-2019	Төр, хувийн хэвшлийн түншлэл	152 320,0	Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувь	2017 онд зарцуулсан 30 464,0 -	АЗБХЗГ: "Концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Хөрөнгө оруулалтын газраас /хуучнаар/ ""Эрчим хүчний барилга угсралтын трест"" ХХК-тай 2015.08.15-ны өдөр концессын гэрээ байгуулан зам барилгын ажлыг эхлүүлж нийт ажлын 5%-ийг гүйцэтгээд байсан боловч "Эрдэнэ зам" ХХК нэхэмжлэл гаргаж, МУ-ын Засгийн газрыг шүүхэд өгснөөр төслийн ажлыг шүүхээс түр зогсоогоод байсныг шийдвэрлэн "Эрчим хүчний барилга угсралтын трест" ХХК-тай байгуулсан гэрээг сэргээсэн. Зам барилгын ажлыг ""Монроуд" ХХК, өдөр тутмын хяналтыг "Аварга зам" ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор зам барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад хүлээлгэн өгнө.	-
7		6. Дашинчилэн-Их тамир чиглэлийн 130 км авто замын Орхон голын 220 урт метр төмөр бетон гүүрийг барих	2018-2019	Улсын төсөв	9,450.0	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь	2,835.0	АЗБХЗГ: Инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулсан. 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.	-

8		13. Баянхонгор-Арвайхээр чиглэлийн огцом эргэлтийн 4.4 км трасс өөрчлөх	2018	Улсын төсөв	3,300.0	Барилгын ажлыг дуусгах	3,300.0	АЗБХЗГ: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаад байна.	-
9		14. Алтай-Дарви чиглэлийн 263 км хатуу хучилттай авто замыг барих	2016-2017	Төр, хувийн хэвшлийн түншлэл	283 920,0	Барилгын ажлыг дуусгах	70 980,0 2017 онд зарцуулсан - Эргэн төлөлт хийх 70,980.0	АЗБХЗГ: Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замыг комиссын 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 07/04/17 дугаар актаар баталгаажуулан улсын ашиглалтад оруулсан. Тус чиглэлийн 165 км хатуу хучилттай авто замын барилгын ажил дуусч, комисс ажиллаж, 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 07/16/17 дугаар дүгнэлт, хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан.	100%
10		15. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замыг барих	2016-2017	Гадаад зээл	28 980,0	Барилгын ажлыг дуусгах	24 840,0 2017 онд зарцуулсан -	АЗБХЗГ: Захиалагч 2016 оны 12 дугаар сард тус авто замын барилгын ажлын гэрээг дүгнэн хөрөнгийн эх үүсвэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан гэрээг дуусгавар болгосон. Барилгын ажил 60%-тай байна. 2018 онд: Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн тендерт оролцогч болох “Чайна Рейлвэй Ферст Групп” ХХК-тай хийсэн гэрээний хэлэлцээр амжилтгүй болсон тул дараагийн бага үнийн санал ирүүлсэн тендерт оролцогч болох “Чайна Коммуникэйшн Констракшн” ХХК-тай гэрээний хэлэлцээр хийсэн. Уг гэрээний хэлэлцээр амжилттай болсон тул тухайн компанитай барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг 2018.03.12-ны өдөр байгуулаад байна.	40%
11		16. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто замыг барих	2016-2018	Гадаад зээл	83 500,0	Барилгын ажлыг дуусгах	66 800,0 2017 онд зарцуулсан 27 851,2	АЗБХЗГ: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нийт 42,198,856.39 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд 2017 онд авто замын барилгын ажлыг 53.5 хувьд хүргэнэ. Нийт ажлын явц 59%-тай байна. 2018 онд: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нийт 42,198,856.39 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд 2018 онд авто замын барилгын ажлыг бүрэн дуусгана. 2018 оны 1-р улиралд барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 138 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн, 2-р улиралд батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018 оны 04 сарын 15-ны өдөр эхлүүлнэ.	40%

12	17. Тосонцэнгэлийн баруун талын 4 замын уулзвараас Нөмрөг-Сонгино чиглэлийн 167 км хатуу хучилттай авто замыг барих	2018-2020	Төр, хувийн хэвшлийн түншлэл	198,700.0	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь	19,870.0	АЗБХЗГ: "Концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газраас "Монгол ЛЗ зам гүүр" ХХК-тай 2017.03.30-ны өдөр концессын гэрээг шинэчилж байгуулсан. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/01/2018 дугаартай зөвшөөрлийг 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр олгосон.	-
13	18. Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто замыг барих	2016-2018	Төр, хувийн хэвшлийн түншлэл	148 700,0	Барилгын ажлыг дуусгах	104 090,0 2017 онд зарцуулсан - 44,610.0	АЗБХЗГ: Үндэсний хөгжлийн газраас барилгын ажлыг гүйцэтгэх концессын гэрээг "Хос мөнгөн зам" ХХК-тай байгуулсан бөгөөд барилгын ажлыг эхлүүлсэн. Нийт зам, барилгын ажлын явц 80%-тай байна.	70%
14	22. Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн хатуу хучилттай авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн дуусгах	2016-2020	Улсын төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл	143 086,0	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь	14 308,6 2017 онд зарцуулсан - 28,617.2	АЗБХЗГ: Өмнөговь аймгийн зүгээс өөрсдийн хөрөнгөөр гүйцэтгүүлэхээр Даланзадгад-Баяндалай-Гурвантэс чиглэлийн 302.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэх гэрээг "Дарданговь" ХХК-тай байгуулсан бөгөөд 2016 онд нийт 56 км авто замыг барьж ашиглалтад оруулсан. 2017 онд орон нутгийн зүгээс уг замыг үргэлжлүүлэн 25 км авто замын барилгын ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж, 09 дүгээр сарын 06-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн.	70%
15	23. Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-Улаанбаатар чиглэлийн 32 км хурдны	2016-2018	Гадаад зээл	154 000,0	Барилгын ажлыг дуусгах	83 700,0 2017 онд зарцуулсан	АЗБХЗГ: Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.226 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Төмөр замын 4-р групп" компани шалгарч 2015 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр нийт 140,335,893.00 ам.долларын барилгын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд гэрээний дагуу 2017 онд авто замын барилгын ажлыг 62.2 хувьд хүргэж , 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдөр ашиглалтад оруулна.	40%

		авто замыг барьж дуусгах					40 430,1 70,300.0	Авто замын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, улсын экспертизээр баталгаажуулсан бөгөөд хурдны авто замын ПК3+000-ПК17+200 хооронд барилгын ажил хийгдсэн. Үүнд: Жилийн эцсийн байдлаар авто замын замын далангийн ажил 98%, хиймэл байгууламжийн ажил 94%, буталсан чулуун болон цементээр бэхжүүлсэн суурь ажил 49% тус тус хийгдсэн байна. Нийт 6 гүүр баригдахаас 4 гүүрийн барилгын ажил дууссан, 2 гүүрийн ажил 88%-тай, 20 дөрвөлжин хоолой баригдахаас 15 хоолойны ажил дууссан, 5 хоолойны ажил 10-80%-ийн гүйцэтгэлтэй, 28 дугуй хоолой баригдахаас 23 хоолойны ажил дуусч, 5 хоолойны ажил 10-82%-ийн гүйцэтгэлтэй байна. Нийт ажлын явц 54.2%-тай байна. 7.8%-ийн хоцролттой. 2018 онд: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 368 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн бөгөөд 2-р улиралд батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2018 оны барилга угсралтын ажлыг 04 сарын 15-ны өдөр эхлүүлнэ.	
16		24. Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн 52.57 км хатуу хучилттай авто замыг барих	2018-2019	Улсын төсөв	32,500.0	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь	9,750.0	АЗБХЗГ: Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2017 онд "Ар Си Эс Си" ХХК боловсруулсан. 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.	-
17		25. Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замыг Мөрөн-Тариалан чиглэлийн замтай холбох 120 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх	2018-2020	Төр, хувийн хэвшлийн түншлэл	14,230.0	Барилгын ажлыг эхлүүлэх	1,030.0	АЗБХЗГ: Концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Үндэсний хөгжлийн газраас "Шинжиан" ХХК-тай 2017.01.12-ны өдөр концессын гэрээ байгуулсан ба 2017.08.16 болон 2017.10.11-ний өдөр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Зам барилгын ажлыг эхлүүлэх 06/18/201 дугаартай зөвшөөрлийг 2017 оны 12 дүгээр сарын 26-ны өдөр олгосон.	70%
18		27. Чоно харайхын голын 37.68 урт метр гүүрийг барих	2018-2019	Улсын төсөв	1,400.0	Барилгын ажлын гүйцэтгэл 90 хувь	1,260.0	АЗБХЗГ: 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй байна.	-

		/Ховд аймаг Дөргөн сум/							
19		28. Даланжаргал ан-Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай авто замыг барих	2018- 2019	Улсын төсөв	14,600.0	Барилгы н ажлын гүйцэтгэ л 40 хувь	5,840.0	АЗБХЗГ: Төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг сайжруулах зорилгоор "Барих-шилжүүлэх" нөхцөлтэйгөөр хэрэгжих концессын зүйлийн жагсаалтыг Улсын Их Хурал тухайн жилийн төсвийн тухай хуулийн хавсралтаар батлахаар 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Үндэсний хөгжлийн газраас Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч хасагдсан байна. Цаашид уг төслийг концессын "Барих-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй байна.	-
20		32.Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын 72.8 урт метр төмөр бетон гүүрийг барих	2016- 2017	Улсын төсөв	3 100,0	Гүүрийг барьж ашиглал тад оруулах	3 100,0 2017 онд зарцуул- сан 1 000,0	АЗБХЗГ: Ерөнхий гүйцэтгэгчээр "Эйч Кэй Би интернэшнл холдинг" ХХК ажиллаж, Увс аймгийн Ховд сумын Шивэрийн голын 72.8 урт метр төмөрбетон гүүрийн барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдөр комисс ажиллаж, 2016 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 7/19/2016 дугаар актаар ашиглалтад авсан.	100%
21		33. Тавантолгой, Сайншанд чиглэлийн бетонон хучилттай, хүнд даацын 500 км авто зам барих ТЭЗҮ-ийг боловсруулж, хөрөнгө оруулалтын нөхцөлийн тохиролцоо, судалгаа хийх	2018	-	-	ТЭЗҮ-ийг боловср уулах	-	АЗБХЗГ: ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй. Тус төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2018.03.22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Монголын эрдэс баялаг-Уул уурхай-2018" хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад танилцуулсан.	-
22		34. Ховд- Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто замыг барих /Ховд, Увс аймаг/	2018- 2020	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	106,820.9	Барилгы н ажлын гүйцэтгэ л 10 хувь	10,682.0	АЗБХЗГ: Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Гео зураглал" ХХК боловсруулсан. 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй байна.	-

23		35. Алтай-Улиастай чиглэлийн 138 км хатуу хучилттай авто замыг барих /Говь-Алтай, Завхан аймаг/	2018-2020	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	99,457.0	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь	9,945.7	АЗБХЗГ: Инженерийн нарийвчилсан зураг төслийг 2012 онд "Ар Си Эс Си" ХХК боловсруулсан. 2018 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй учраас төслийг хэрэгжүүлэх боломжгүй байна.	-
24	2.108. "Тавантолгой-Гашуун сухайт", "Хөөт-Бичигт" чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна.	1."Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замыг барих	2016-2018	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	2 386 380,0	Барилгын ажлыг дуусгах 1,073,870.0	1 312 510,0 2017 онд зарцуулсан	ТЗДТБХЗГ, "МТЗ" ТӨХК: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016.09.13-ны өдрийн 01/653 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар байгуулагдсан Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдаар ахлуулсан ажлын хэсэг Тавантолгойн орд газар болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор гадаад дотоодын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээ хийсэн. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх тухай Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017.04.11-ний өдрийн 01/1463 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн. Тус чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-аас МУ-д хөнгөлөлттэй зээлээр олгох 1 (нэг) тэрбум ам.доллараас 400 сая ам.доллар олгохоор Засгийн газрын 2017 оны 222 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2017 оны 312 дугаар тогтоолоор дээрх 400 сая ам.доллар олгох тогтоолыг хүчингүй болгосон. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн барилгын ажлыг үргэлжлүүлэн эрчимжүүлэх үүрэг бүхий Уул, уурхайн яам, Үндэсний хөгжлийн газартай хамтарсан ажлын хэсгийг яаралтай байгуулахаар ажиллаж байна. Барилгын ажлын явц 51.84 хувьтай байна. Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 04 дүгээр сард БНХАУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлыг хангах, тээврийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ 2018 оны 01 дүгээр сард БНХАУ-д айлчилсан. Айлчлалын үеэр Хятадын Тээврийн яамтай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлд хамтран ажиллах асуудлыг хэлэлцэж, Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын холболтын цэгийг тохиролцох чиглэлд үргэлжлүүлэн хамтран ажиллахаар тохиролцсон. Энэ оны 04 дүгээр сарын Ерөнхий сайдын айлчлалын үеэр уг төмөр замын асуудлаар Хятадын талтай хэлэлцээг үргэлжлүүлэхээр төлөвлөж байна.	40%
25		2. "Хөөт-Бичигт"	2016-2020	Гадаад зээл,	2 386 380,0	Барилгын ажлын	477 276,0	ТЗДТБХЗГ, "МТЗ" ТӨХК: УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-д тодотгол хийж,	40%

		чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулах , төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх		хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт		гүйцэтгэл 50 хувь	2017 онд зарцуулсан - 715,914.0	Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын суурь бүтцийн царигийн өргөнийг 1435 мм байхаар шийдвэрлүүлсэн. Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын шугамын чигийг Засгийн газрын 2016 оны 146 дугаар тогтоолоор батлуулсан. “Монголын төмөр зам” ТӨХК нь 2015 онд БНХАУ-ын “Башинь төмөр зам” компанитай хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, БНХАУ-ын “Башинь төмөр зам” компанийн захиалгаар БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн ТЭЗҮ-ийг боловсруулсан. 2014 онд Япон улсын Неппон компани тус чиглэлийн төмөр замын техникийн зураг төслийг 2014 онд боловсруулж, МТЗ ТӨХК-д хүлээлгэн өгсөн. Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын төсөл нь Монгол-Орос-Хятадын “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн Төмөр замын зүүн коридор байгуулах төсөлд багтсан. Эдийн засгийн коридорыг хөгжүүлэх хүрээнд “Төмөр замын зүүн коридор-бүс нутаг ба уул уурхайн хөгжил” олон улсын зөвлөлдөх уулзалтыг 2018 оны 1 дүгээр сарын 22, 23-ны өдөр Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтын үеэр талууд төмөр замын зүүн коридороор тээвэрлэх ачаа эргэлт хангалттай бий бөгөөд Забайкальскийкийн төмөр замын ачааг хуваалцах нөхцөл байдал үүсэхгүй гэж үзсэн. “Монголын төмөр зам” ТӨХК нь Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг боловсруулахаар БНХАУ-ын “Башинь төмөр зам” ХХК-тай санамж бичиг байгуулж ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг “Башинь төмөр зам” ХХК-ийн санхүүжилтээр Хятадын Төмөр замын зураг төслийн гуравдугаар хүрээлэн гүйцэтгэсэн. Тус ТЭЗҮ үр ашиг багатай гарсан тул Хөөт орчимд нүүрс боловсруулах, нүүрснээс хий, шингэн түлш гаргах, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах аж үйлдвэрийн парк байгуулж төмөр замтай уялдуулан цогцоор нь хөгжүүлэх, ачааны эх үүсвэрийг нэмэгдүүлж ТЭЗҮ-г шинэчлэн боловсруулж байна. ТЭЗҮ бэлэн болмогц зураг төслийг шинэчлэн боловсруулна.	
26	2.109. “Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана.	2.“Шивээхүрэн-Сэхэ” боомтын төмөр замыг барих	2017	Гадаад зээл, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт	156 200,0	Барилгын ажлыг дуусгах 2017	156 200,0 2017 онд зарцуулсан -	ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК: Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан. “Монголын Алт” ХХК-ийн захиалгаар 2008 онд Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсныг тус компани “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан ТЭЗҮ, зураг төслийг шинэчлүүлсэн. Тус чиглэлийн царигийн өргөний хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Засгийн газрын 2017 оны 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр УИХ-д өргөн барихаар тогтсон. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг Улсын Их Хурлын 2014 оны “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний	-

								тухай” 64 дүгээр тогтоолын 1 дэх заалтад нэмэлт оруулахаар УИХ, Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох материалыг бэлтгэн Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2017 оны 12 дугаар сард хүргүүлсэн. Одоогийн байдлаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй, хүлээгдэж байна. Тус чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх асуудал нь “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн шүүх байгууллагад шалгагдаж байгаа тул уг төмөр замын төслийн ажил зогсонги байдалтай байна.	
27	2.110. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ.	1. “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах, суурь бүтэц барих ажлыг эхлүүлэх	2016-2020	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	2 295 540,0	Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь	6 000,0 2017 онд зарцуулсан - 459,108.0	ТЗДТБХЗГ, “МТЗ” ТӨХК: Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын суурь бүтцийн чиглэл, барих үе шат, уртыг Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д нэмэлтээр тусгахаар Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр ажиллаж байна. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг тогтоолгохоор өмнө нь УИХ-д өргөн барьсан УИХ-ын тогтоолын төслийг Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэлээр эгүүлэн татсан. Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-г боловсруулах чиглэлээр “Монголын төмөр зам” ТӨХК, БНХАУ-ын “Си Ар И Си” компани хооронд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ТЭЗҮ-ийг боловсруулсан бөгөөд Монгол хэл рүү орчуулах ажил хийгдэж дууссан. Төмөр замын зураг төсөл боловсруулах санхүүжилтийг шийдвэрлэснээр зураг төслийг боловсруулна.	40%
28	2.111. Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	1. Улаанбаатар төмөр замын галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах автомат хориглолын систем, диспетчерийн төвлөрүүлэлт нэвтрүүлэх	2016-2018	Улсын төсөв, гадаад эх үүсвэр, бусад эх үүсвэр	120 000,0	УБТЗ-ын тээх, нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх	60 000,0 2017 онд зарцуулсан УБТЗ өөрийн хөрөнгөөр 59 942,525 \$ 60 000,0	ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН: “УБТЗ” ХНН-ийн дохиолол, хориглол, төвлөрүүлэлтийн шинэчлэлийн ажлын хүрээнд УБТЗ-ын 65 өртөө, зөрлөгт дохиолол төвлөрүүлэлт, хориглолын байгууламжийн угсралт, суурилуулалтын ажлыг гүйцэтгүүлэхээр 2015 онд “Элтеза” компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэгч компани төмөр замын шугам замд судалгааны ажлыг хийж дуусгасан ба батлагдсан ажлын даалгаврын дагуу гол тоологчийн тусламжтайгаар хоорондын замын чөлөөтэй байдлыг хянах систем, хоорондын замд галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулах систем, галт тэрэгний захирагчийн төвлөрүүлэлтийн систем, цахилгаан тэжээлийн системийн байгууламжийн техникийн шийдлүүдийн зураг хийгдэж бүрэн эхээр нь хүлээн авсан. Төслийн явц 70%-тай. Дээрх ажлыг 2018.03.11-нд дуусгах байсныг өвлийн улиралд радио долгионы антен суурилуулах ажил хийхэд хүндрэлтэй байгаа тул 6 сараар сунгаж 2018 оны 09 дүгээр сарын эхээр дуусгах төлөвлөгөөтэй ажиллаж байна.	70%

								<p>2016-2017 онуудад Төслийн гүйцэтгэлд зарцуулах мөнгөн дүн болох 680 346 200 ам.доллараас 2017 оны 3-р улирлын байдлаар 36 299 745 ам.долларын төлбөр хийгдсэн.</p> <p>“УБТЗ” ХНН-д хэрэгжиж буй “Хөдөлгөөнт радио холбооны систем ба холбооны системээр галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах авто хориглолын систем ба удирдлагын төвлөрсөн системийн зураг төсөл, нийлүүлэлт, угсралт” УБЖД 15/60 тоот гэрээний нийт ажлын эхлэл 95%, төхөөрөмж нийлүүлэлт 93.3%, төхөөрөмж угсралт 32.3% байна. Санхүүжилтын байдал 2016-2018 онд нийт 69'841'533 ам доллар байгаагаас 2018 оны хувьд 7'407'790 ам доллар байхаар төлөвлөгдсөн.</p> <p>2018 оны эхний улирлын байдлаар “УБТЗ” ХНН-ийн ШЧ-1, ШЧ-2 ангиудын Тетра радио холбооны зураг төслүүдийг улсын экспертизээр оруулах ажлыг хийж байна. Галт тэрэгний хөдөлгөөний диспетчерийн төвлөрүүлэлтийн төвийн үйл ажиллагааны тайланг “Информтехника и связь” ХХК-д дүгнэлт гаргуулахаар илгээсэн. Холбооны ангиудын өртөөдөд суурилуулах диспетчерийн суурилуулалтын системийг хүлээн авсан ба угсрах ажлыг эхлүүлсэн. ШЧ-1-ийн 16 өртөө зөрлөгт /63%/, ШЧ-2-ын 14 өртөө зөрлөгт /52%/, ШЧ-3-ын 13 өртөө зөрлөгт /52%/ тус тус угсралтын ажил хийгдсэн.</p> <p>Нийт 20 хос зүтгүүрт зүтгүүрийн кабины хориглолын системийг суурилуулахаас 2018 оны эхний байдлаар 2 хос зүтгүүрт суурилуулсан ба туршилтын ажлыг эхлүүлэхээр бэлтгэл ажил хийгдэж байна.</p>	
29	2.Улаанбаатар төмөр замын гол замын их засварын ажлыг гүйцэтгэх /200 км/	2016-2020	Улсын төсөв, гадаад эх үүсвэр, бусад эх үүсвэр	149 100,0	Гол замд 2017 онд 50 км, 2018 онд 100 км их засварын ажил гүйцэтгэх	37 275,0 2017 онд зарцуулсан УБТЗ өөрийн хөрөнгөөр 26 100.0 37,275.0	<p>ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН: “Улаанбаатар төмөр зам” ХНН нь 2016 онд гол замын 17 км замд их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2017 оны 05 дугаар сарын 29-ний өдөр гол замын их засварын ажил эхэлсэн. Графикийн дагуу 7 хоног бүрийн мягмар, баасан гарагт 8 цаг хөдөлгөөн хааж /цонх/ засварын ажлыг хийж 50 км замд их засвар хийж дууссан.</p> <p>2018 онд “УБТЗ” ХНН-ийн төлөвлөгөөнд 80 км замд их засвар хийхээр тусгагдаад байна. Засварын ажлыг энэ оны 04 дүгээр сард эхлүүлнэ.</p>	-	
30	3.“Богдхан” төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэх	2017-2020	Гадаад зээл, төр, хувийн хэвшлийн түншлэл	1 125 000,0	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь	3 000,0 2017 онд зарцуулсан - 337,500.0	<p>ТЗДТБХЗГ: Богдхан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр ЗТЯ болон АХБ хооронд 2014 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсны дагуу АХБ-наас үзүүлж буй техникийн туслалцаагаар “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй зөвлөх компани “УБТЗ” ХНН-ийн Мандал өртөөнөөс Багахангай чиглэлд шинээр барих “Богдхан” төмөр зам төслийн чигийн судалгааг боловсруулсан.</p> <p>Зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017 оны 09 дүгээр арын 22-ны өдөр ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг ЗГ-ын хуралдаанаар батлуулах шийдвэр гарсан. Зөвлөх</p>	40%	

								компани чигийн судалгааны эцсийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ЗТХЯ-нд хүлээлгэж өгсөн. Зам, тээврийн хөгжлийн яам (хуучин нэрээр), Азийн хөгжлийн банк хооронд 2014 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд АХБ-ны техникийн туслалцаагаар Богдхан төмөр замын чигийн судалгааны ажлыг “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй түншлэл гүйцэтгэсэн. Үлдэгдэл техникийн туслалцааны хүрээнд уг төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах санхүүжилтийг АХБ-ны 2018-2020 оны Монгол улс дахь үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд тусгуулах саналыг СЯ руу хүргүүлээд байна. Мөн ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга АХБ-ны төлөөлөлтэй 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдөр уулзаж АХБ-наас үзүүлж буй техникийн туслалцааны төслийг цаашид үргэлжлүүлэн “Богдхан” төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх саналыг тавиад байна.	
31		4. “Улаанбаатар төмөр зам” ХНН байгуулах тухай 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх	2016-2020	-	-	-	-	ТЗДТБХЗГ: 2017 онд: МУ-ын Ерөнхий сайдын 2016 оны 71 дүгээр захирамжаар байгуулагдсан Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг шинэчлэх талаар оросын талтай хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн дэд сайдаар ахлуулж, холбогдох яамдыг төлөөлсөн 17 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг 2016.10.13-ны өдөр хуралдаж, гишүүд удирдамжийн төсөлд санал ирүүлэхээр тогсоны дагуу гишүүдийн ирүүлсэн саналыг нэгтгэсэн. Зам, тээврийн хөгжлийн сайд Москва хотод “Оросын төмөр замууд” нээлттэй хувьцаат нийгэмлэгийн ерөнхийлөгчтэй 2016.12.08-ны өдөр уулзаж, уг асуудлаар хэлэлцсэн. 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Ажлын хэсгийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу Оросын талтай хэлэлцээ хийх ажлын хэсгийн удирдамжийн төслийг боловсруулах хурлыг тус яамны гишүүдийн түвшинд 3 удаа зохион байгуулж ажилласан ба Хэлэлцээрийг шинэчлэх талаар баримтлах удирдамжийн төсөлд өөрчлөлт оруулж байна. Ажлын хэсгийн явцын талаар Зам, тээврийн хөгжлийн сайдад 2017.07.17, 21-ний өдөр тус тус танилцуулан өгсөн чиглэлийн дагуу ТЕГ-т Зам, тээврийн дэд сайдын 2017.08.03-ны өдрийн 02/3409 тоот албан бичиг хүргүүлж, холбогдох хүмүүсээс санал авсан. Ажлын хэсэг 2017 оны 3 дугаар улиралд Хэлэлцээрийг шинэчлэх төсөл, хэлэлцээрийг шинэчлэх талаар оросын талтай яриа хэлэлцээнд баримтлах удирдамжийн төслийг боловсруулсан. Түүнчлэн хэлэлцээрийг дагаж батлагдсан хавсралт протоколуудыг судалж, хэлэлцээрийн уйгаржингаас хөрвүүлсэн эх бичвэрийг тулгаж, хэлэлцээрийн төслийг боловсруулж, 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдөр Зам, тээврийн хөгжлийн сайдад танилцуулсан. 2018 онд: “БНМАУ-ын Засгийн газар ба Зөвлөлийн Засагт Нийгэм Журамт Бүгд Найрамдах Холбоот Улсын Засгийн газар хооронд байгуулсан	-

								<p>“Монгол-Зөвлөлтийн Хувь нийлүүлсэн нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай” 1949 оны хэлэлцээрийн наймдугаар зүйлийн “ж”-д төмөр замын барилга болон ашиглалтад чухал хэрэглэгдэх төхөөрөмж материалуудыг гааль, татвар хураахгүйгээр Монгол Улсад нэвтрүүлэн оруулж байхыг зөвшөөрсөн байдаг. Энэхүү хэлэлцээрийн дагуу төмөр замын хэрэгцээнд нийлүүлэгдэж байдаг технологийн зориулалттай техник, тоног төхөөрөмж, дизелийн түлш, моторын тос, үйлдвэрлэл-техникийн зориулалттай материал, сэлбэг хэрэгсэл нь гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөгдөж ирсэн хэдий ч “Улаанбаатар төмөр зам” ХНН өөрийн хэрэгцээнд импортолсон авто бензин болон дизелийн түлшинд 1998-2015 онуудад 76 195 156 000 төгрөгийн албан болон онцгой албан татвар төлсөн бөгөөд Гаалийн ерөнхий газар 2016 онд 31.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төлүүлэхээр нэхэмжилж байгаа болно. “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн Оросын талын хувь нийлүүлэгчийн зүгээс дээрх албан татварыг төлж байгаа асуудал нь 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр зөрчиж буй асуудал гэж үзэн, авто бензин, дизелийн түлшинд онцгой албан татвар төлөлтийг зогсоож, урьд төлсөн татварыг зээлийн өрийн төлбөрт тооцох талаар 2009 оноос эхлэн холбогдох бүх шатанд хүсэлт, шаардлагыг тавьж эхэлсэн. Иймд энэхүү асуудлаар Монгол Улсын Их хурлаас 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн “Онцгой албан татвараас чөлөөлөх тухай” хуулийг баталж, “Улаанбаатар төмөр зам” ХНН-ийн өөрийн хэрэгцээнд импортоор оруулах дизелийн түлшийг 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн онцгой албан татвараас чөлөөлсөн байдаг. Түүнчлэн “Монгол-Зөвлөлтийн Хувь нийлүүлсэн нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай” 1949 оны хэлэлцээрийн наймдугаар зүйлийн “ж” заалтыг үндэслэн “УБТЗ” ХНН-ийн 1998-2015 онуудад төлсөн дизелийн түлшний онцгой албан татварын 73.8 тэрбум төгрөгийг Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Банкнаас төмөр замын тээврийг сэргээн сайжруулахад зориулж авсан МОНП-1, МОНП-2 хөнгөлөлттэй зээл, зээлийн хүү, алдангиас суутгуулан тооцуулах асуудлыг Засгийн газрын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж Улсын Их Хурлаар шийдвэрлүүлэхээр тогтсон. Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг боловсруулж СЯ, ХЗДХЯ-нд санал авахаар тус тус хүргүүлээд байна. Иймд “УБТЗ”-ын санхүүгийн томоохон асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа энэ үед “Монгол-Зөвлөлтийн Хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийг үүсгэн байгуулах тухай” 1949 оны хэлэлцээрийг шинэчлэх чиглэлээр хэлэлцээг үргэлжлүүлэх нь цаг хугацааны хувьд тохиромжгүй байдал үүсээд байна.</p>	
32	2.112. “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг	1. “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг	2016-2020	Гадаад зээл, төр, хувийн хэвшлийн түншлэл	2 820 250,0	Барилгын ажлын гүйцэтгэл 55 хувь	564 050,0	ТЗДТБХЗГ, Концесс эзэмшигч “Нортерн рейлвейс” ХХК: Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, техникийн зураг төслийг СМЕК компани боловсруулж, Концесс эзэмшигч “Нортерн рейлвэйс” ХХК-д хүлээлгэн өгсөн.	40%

	барьж байгуулах ажлыг эхлүүлнэ.	барих ажлыг эхлүүлэх					2017 онд зарцуулсан “Нортерн рейлвейс” ХХК өөрийн хөрөнгөөр 750,0 987,090.0	Тус чиглэлийн төмөр замын чигийг Засгийн газрын 2017 оны 10 дугаар тогтоолоор батлуулсан. 2017.06.20-ны өдөр Эрдэнэт хотод төмөр замын барилгын ажлын нээлтийн шав тавих ёслолыг хийсэн. "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" нөхцөлтэй концессоор хэрэгжиж буй Эрдэнэт-Овоот чиглэлийн төмөр замын төслийн концесс эзэмшигч “Нортерн Рэйлвэйс” ХХК нь уг төмөр замын төслийн ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг гүйцэтгүүлэх, цаашид хамтран ажиллахаар БНХАУ-ын Чайна гэжуба групп корпорацитай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн дагуу Чайна гэжуба групп корпораци нь олон улсын банк, санхүүгийн байгууллагын шаардлага хангасан ТЭЗҮ-ийг боловсруулж дуусаад байна. Одоогийн байдлаар ТЭЗҮ-г хянах, тодруулга авах, санал солилцох ажил хийгдэж байна. Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэснээр 2019 онд төмөр замын барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна.
33	2.113. Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна.	1.Хөшигийн хөндийд тээвэр ложистикийн төв байгуулах	2017-2020	Гадаад эх үүсвэр	216 940,0	Барилгын ажлын гүйцэтгэл 30 хувь	10 850,0 2017 онд зарцуулсан - 65,080.0	БТГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗХ: Хөшигийн хөндийд тээвэр ложистикийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулах, судлах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг ажлын даалгаврыг боловсруулж ЗТХЯ-ны ТНБД-аар батлуулсан. Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгаврын төсөлд Хөшигийн хөндийд олон улсын ачаа тээврийн ложистик төв, зорчигч тээврийн терминалыг барих, тээврийн хэрэгслийн нэгдсэн авто зогсоолыг төлөвлөх санал хүргүүлсэн. “Логистикийн салбарын чадавхийг бэхжүүлэх техникийн туслалцаа CDТА 8080 MON төсөл”-ийг хэрэгжүүлж буй КРМГ компанийн явцын болон эцсийн тайлантай танилцаж санал, зөвлөмж, үйл ажиллагааны чиглэл өгч ажилласан. Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудалтай уялдуулан Улаанбаатар ложистикийн төвийг байгуулах судалгаа хийгдсэн. Эцсийн тайланг ЗТХЯ-нд ирүүлээд байна. Тайланг хүлээн авч баталгаажуулахаар ажиллаж байна. Улаанбаатар хотын ОУШНБ-ын Ашиглалтын өмнөх захиргааны албанаас гаргасан “Ачаа, тээврийн судалгаа”-нд далайд гарцгүй манай орны хувьд дотоодын ложистикийн салбарыг хөгжүүлэх нь улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой гэж дүгнэсэн бөгөөд тус алба нь газар зүйн байршлын давуу талыг ашиглан Монгол Улсыг тив дамнасан зорчигч болон ачаа тээврийн дамжин өнгөрөх зангилаа болгох боломжийг нарийвчлан судалж байна. Хөшигийн хөндийн тээврийн ложистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах хөрөнгийн асуудал шийдвэрлэх ажлын хүрээнд МУ-ын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтад танилцуулга хүргүүлээд байна. АХБ-ны холбогдох мэргэжилтэнтэй 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр уулзалт хийж, энэхүү асуудлыг танилцуулсан боловч АХБ-ны 2017 онд санхүүжүүлэх

							<p>төслийн жагсаалтад Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах асуудал тусгагдаагүй тухай мэдэгдсэн.</p> <p>Богдхан төмөр замын чигийн судалгаа 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс АХБ-ны техникийн туслалцаагаар эхлээд байна. Энэ ажил хийгдсэний дараа Хөшигийн хөндийн тээврийн логистикийн төв байгуулах байршил, ТЭЗҮ хийх үндэслэл бүрдэнэ.</p> <p>Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төв байгуулах санал тусгасан.</p> <p>Логистикийн салбарын чадавхыг бэхжүүлэх техникийн туслалцааны зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа "КМПЖ" ХХК-ийн эцсийн тайлантай танилцаж, дотоодын ачаа тээвэрлэлтийг бүтээгдэхүүн тус бүрээр харьцуулсан судалгаа хийж тодорхой асуудлыг загварчилж, төсөөллийг гаргаж саналаа дэвшүүлсэн боловч дүгнэлт, бодлогын зөвлөмжүүд гаргаагүй тул асуудлыг тодорхой болгох талаар саналаа хүргүүлээд байна. Бодлогын зөвлөмж гарсны дараа ТЭЗҮ-ийг холбогдох байгууллагуудтай хамтарч боловсруулахаар төлөвлөж байна. Логистикийн сүлжээний зураглал гаргах зөвлөх үйлчилгээ үзүүлж буй "Монголын логистикийн холбоо" ТББ-ын дунд шатны тайлантай танилцаад саналаа хүргүүлэв. Энэхүү судалгааг 2018 оны 05 дугаар сарын 01-ээс өмнө хийлгэж дуусгахаар ажиллаж байна.</p> <p>Богдхан төмөр зам, Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулахаар АХБ-тай Зам, тээврийн яам /хуучин нэрээр/ 2014 оны 10 дугаар сард санамж бичиг байгуулсан. Богдхан төмөр замын чигийн судалгааг 2017 онд АХБ-ны техникийн туслалцаагаар гүйцэтгэсэн. Богдхан төмөр замын трасс батлагдсны дараа Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. Хөшигийн хөндийн тээвэр логистикийн төвийн ТЭЗҮ боловсруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор АХБ-ны 2018-2020 онд Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөнд тусгуулах саналыг 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 04/777 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлээд байна.</p>	
34	2.Замын- Үүдэд тээвэр логистикийн төв байгуулах	2016- 2019	Гадаад эх үүсвэр	155 330,0	Барилгын ажлын гүйцэтгэл 95 хувь	<p>124 264,0</p> <p>2017 онд зарцуулсан</p> <p>31 244,8</p> <p>23,300.0</p> <p>БТГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ: Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй "Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төсөл"-ийн хүрээнд улсын төсвийн 16,335,000,000 төгрөгний санхүүжилтээс нийтдээ 11,938,000,000 төгрөгийн авто зам, гүүрэн байгууламж, хамгаалалтын хашааны барилга угсралтын ажил, эрчим хүчний шугам, 16 Квт-ын дэд станцын барилгын ажил, цэвэр усны шугамын, холбоо интернэтийн шилэн кабелийн, цахилгаан эрчим хүчний шугам, 110 Квт-ын дэд станцын барилгын ажил хийгдсэн.</p> <p>2017 онд улсын төсвийн санхүүжилтээр 4 397 000 000 төгрөгийн логистикийн төвийн 50 тн-ийн даацтай вандан кран нийлүүлэх ажил хийгдэхээр тендер зарлагдан Хятад улсын "Хэнань Дафан Хүнд Машин</p>	70%	

							<p>механизм” компани шалгаран гэрээ байгуулсан ба гэрээний 40%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба нийт төлөгдөх ёстой санхүүжилтын 71 % хийгдсэн. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэх Логистикийн төвийн барилга угсралтын ерөнхий гүйцэтгэгчээр “Хятадын төмөр замын 21-р товчоо” компани, хяналтын зөвлөхөөр БНСУ-ын “Сүсонг инженеринг компани”, Монгол Улсын “Геозураглал”, “NBCC” ХХК-уудын түншлэл ажиллаж байгаа бөгөөд 32 400 313 ам.долларын санхүүжилт хийгдсэн. Нийт барилгын ажлын гүйцэтгэл 81%-тай.</p> <p>2018 оны барилга угсралтын ажлыг 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлүүлэхээр төлөвлөгөө батлагдсан. Засгийн газрын 2018 оны 72 дугаар тогтоолоор гадаадаас ажиллах хүч авахаар шийдвэр гарч тус логистикийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх 230 ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн.</p> <p>Сангийн яаманд барилгын ажлын гүйцэтгэлийг хянан санхүүжилт шийдвэрлүүлэхээр албан хүсэлт хүргүүлсэн ба асуудал шийдвэрлэгдвэл барилгын ажил эхлүүлэхэд бэлэн байна.</p> <p>Тухайн төслийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн ажлын гүйцэтгэлийг хянан Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Логистикийн төвийн үйл ажиллагаанд ашиглах 50 тн-ийн даацтай 2 вандан краны нийлүүлэлт, угсралт, туршилтын ажлын гүйцэтгэгч болох Хятадын “Хэнань Дафан Хүнд Машин механизм” ХХК-ийн ажлын гүйцэтгэл 40%-тай байна.</p> <p>Логистикийн төвийн төмөр замын дохиолол, холбооны зураг төсөл, ханган нийлүүлэлт, угсралт суурилуулалт, засвар үйлчилгээний ажлын худалдан авах үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэгчээр China Railway 21st Bureau Group шалгарч Зам, тээврийн хөгжлийн яамтай 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулаад байна.</p>	
35		3.Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа хийх, батлах	2017-2018	-	-	Төрөөс логистикийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах	<p>БТГ, АТБХЗГ, ТЗДТБХЗГ, АЗБХЗГ, АТБХЗХ: Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах чиглэлээр судалгаа хийж зураглал гарган, ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар байгуулсан. Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгааны ажлыг 2017 онд 25.0 сая төгрөгөөр хийхээр зам, тээврийн салбарын норм нормативыг боловсронгуй болгох сангийн 2017-2018 оны төлөвлөгөөнд тусгасан. Уг ажлын хүрээнд ачаа тээврийн хэмжээ, хэтийн төлөвийг судлан, ачаа үүсэх, шингээх гол цэгүүдийг тодорхойлон, замын сүлжээтэй уялдуулан тээвэр логистикийн төвүүдийн байршлыг тодорхойлох ажлыг хийхээр төлөвлөсөн.</p> <p>Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Монголын логистикийн холбоо” ТББ-тай 2017 оны 267 дугаар гэрээг байгуулсан.</p> <p>Логистикийн сүлжээний зураглал гаргах зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Монголын логистикийн холбоо” ТББ-ын дунд шатны тайлантай танилцаад саналаа хүргүүлэв. Энэхүү судалгааг энэ оны 05 дугаар сарын 01-ээс өмнө хийлгэж дуусгахаар ажиллаж байна. Зөвлөх үйлчилгээ</p>	40%

								үзүүлж буй байгууллагын судалгаа гаргаж дууссны дараа зураглалыг холбогдох байгууллагаар батлуулахаар төлөвлөж байна.	
58		2.Азийн авто замын сүлжээгээр автотээвэр гүйцэтгэх тухай ЗГ хоорондын хэлэлцээрийг эцэслэн	2016-2017	-	-	Хэлэлцэрийг эцэслэн байгуулах	-	АТБХЗГ: "Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төслийн жагсаалт"-ын 12 дугаарт туссан "Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай ОХУ, МУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т Москва хотноо 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдөр гурван улсын тээврийн сайд нар гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээрийг УИХ-аар соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын 2017 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжээд хуулийн төслийг УИХ-ын холбогдох байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсон. Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж	70%

		байгуулж, хэрэгжүүлэх						байна. Гэвч УИХ-ын Тамгын газраас Засгийн газар шинээр эмхлэн байгуулагдсантай холбогдон Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан баримт бичгийг шинэчлэн ирүүлэх шаардлагатай гэсэн шалтгаанаар буцаасан тул хуулийн үзэл баримтлалыг дахин батлуулж, Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийг УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг төлөвлөгөөг Засгийн газрын тогтоолоор батлуулахаар ажиллаж байна. НҮБ-ын АНДЭЗНК-оос “Азийн авто замын сүлжээгээр олон улсын авто тээвэрлэлт гүйцэтгэх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах гурван улсын тээврийн сайд нарын зөвлөлдөх уулзалтыг 2017 оны 08 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд ОХУ-ын Улаан-Үд хотноо зохион байгуулсан. Уг хуралд Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл оролцсон. Уулзалтын үеэр хэлэлцээрт гарын үсэг зурсан талууд хэлэлцээрийг хэрэгжүүлэх бэлтгэлийн ажлын талаар мэдээлэл харилцан мэдээлэл хийж, хэлэлцээрийг хэрэгжилтийг зохицуулах нэгж байгуулах саналыг НҮБ-ын АНДЭЗНК-ийн Тээврийн хэлтсийн даргад тавьсан бөгөөд саналыг нааштайгаар хүлээн авсан.	
59	2.117. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ.	1. Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлэх	2017-2020	-	-	Судалгаа хийгдэх Хууль батлагдах -	-	<p>ТЗДТБХЗГ, Далайн захиргаа:</p> <ul style="list-style-type: none"> - Далайн тээврийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор Монгол Улс, Хятад Улсын нутаг дэвсгэрээр далайд гарах болон буцах, дамжин өнгөрөх тээвэр хийх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд 1991 онд байгуулсан хэлэлцээрийг 2014 онд шинэчлэн байгуулсан ба уг хэлэлцээрийг Хятадын тал баталсан тухайгаа 2017 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн нот бичгээр манай талд мэдэгдсэнээр тус хэлэлцээр хүчин төгөлдөр болж, Монгол Улс, БНХАУ-ын хойд болон зүүн хойд бүс нутгийн гадаад худалдаанд нээлттэй далайн 7 боомтыг ашиглах эрх зүйн орчин бүрдэв. - Олон улсын Далайн байгууллагаас Монгол Улсын далайн салбарт хийсэн аудитын шалгалтын дүгнэлт, зөвлөмж (тухайлбал, далайн чиглэлээр Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын конвенциудын заавал хэрэгжүүлэх шаардлагатай холбогдох заалтыг үндэсний хууль тогтоомждоо тусгасан байх шаардлага)-ийн дагуу Далай ашиглах тухай хуулийн үзэл баримтлалын болон шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахаар ажиллаж байна. Хууль батлагдсанаар хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчин сайжирна. - Хөлөг онгоцны бүртгэлийн эрх зүйн орчныг олон улсын стандартад нийцүүлэхийн тулд хөлөг онгоцны нээлттэй бүртгэлийг эрхэлдэг Панам, Вануату, Болив, Молдав зэрэг улсуудын бүртгэлийн үйл ажиллагааг судалж, Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн агентын гэрээний загварыг боловсруулж, хөлөг онгоцны бүртгэл хийх боломжит агентуудыг сонгон шалгаруулахаар ажиллаж байна. - Хөлөг онгоц бүртгэлийн цахим систем “Monfleet.com”-ийг шинэчлэн боловсронгуй болгох, хөлөг онгоц бүртгэл хийхдээ Далайн захиргааны 	100%

							<p>зөвшөөрлийг үндэслэн бүртгэлийн гэрчилгээг хэвлэх, хөлөг онгоцны мэдээллийг төрөл, даацаар нь ангилах зэрэг ажлыг төлөвлөж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Монгол-Сингапурын хамтарсан "Монголын хөлөг онгоцны бүртгэл" компанийн ТУЗ-ийн ээлжит хурлыг зохион байгуулж, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, нийт албан хаагчдын ажил байдлын тодорхойлолтыг шинэчлэн батлуулав. - Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийг Улаанбаатар боомтод төвлөрүүлэх зорилгоор "Монголын хөлөг онгоцны бүртгэл" компанийн батлан олгож байсан хөлөг онгоцны гэрчилгээний загварыг олон улсын холбогдох конвенциудын дагуу шинэчлэн боловсруулж Далайн захиргаанаас олгох, хөлөг онгоцонд олгох бүртгэлийн дугаарыг мөн Далайн захиргаанаас олгох ажлыг тус тус эхлүүлэв. - Хөвсгөл нуурт аюулгүй, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах бодлогын хүрээнд Олон улсын эрэн хайх авран хамгаалах холбооны Герман улсын салбарын дэмжлэгээр усан орчинд эргүүл хийх, аврах ажиллагааны зориулалттай тусгай тоноглогдсон завийг Монгол Улсад оруулж ирүүлэх асуудлыг зохицуулж байна. - БНХАУ-ын буцалтгүй тусламжаар Хөвсгөл нуурт эргүүл хийх завь катерыг усанд тавьснаар усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах эргүүл хийх, авран туслах нийт 3 завьтай болсон. - Усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тус яамны харъяа Далайн захиргааны ажилтнуудад усан замын тээврийн улсын байцаагчийн эрхийг зохих байгууллагаар шийдвэрлүүлэн олгож хяналт хийлгэхийн зэрэгцээ тус захиргааны ажилтнууд 7-10 хоногоор ээлжлэн Хөвсгөл нуурт ажиллаж хяналт тавьж байна. <p>ОУДБ-ын "Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай" 1978 оны конвенцийн 2010 оны Манилагийн нэмэлт, өөрчлөлт болон Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын "Далайн хөдөлмөрийн тухай" 2006 оны конвенцийн 2010 оны нэмэлт, өөрчлөлтийг эх хэлнээ хөрвүүлж, гадаад яамнаас санал авахаар хүргүүлээд байна. Далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 02 дугаар сарын 21-ний 27 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд ажлын хэсгийн гишүүдэд Олон улсын далайн байгууллагын хуульчдаас боловсруулж ирүүлсэн хуулийн төсөл болон тус байгууллагаас Монгол Улсын далайн салбарын үйл ажиллагаанд хийсэн Аудитын дүгнэлт, зөвлөмж, хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын анхны төслийг хүргүүлж, саналыг нь бэлтгүүлж байна.</p>	
60	2. Далбааны эзэн улсын үүрэг, хариуцлагын тогтолцоог боловсронгуй	2017-2020	Бусад эх үүсвэр	800,0	Хяналтыг хэрэгжүүлэх үндэсний мөргөжилт энг	200,0 2017 онд зарцуулсан	<p>ТЗДТБХЗГ, "Далайн захиргаа" УТҮГ</p> <ul style="list-style-type: none"> - Аудитын шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн дагуу далбааны эзэн улсын үүрэг, хариуцлагын тогтолцоог үе шаттайгаар боловсронгуй болгох 2 жилийн төлөвлөгөөг Олон улсын Далайн байгууллагатай хамтран баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна. 	40%

		болгож, Монголын хөлөг онгоцны бүртгэлийн чанарыг сайжруулах, өргөжүүлэх				Бэлтгэх, судалгааны ажил хийж Хяналтыг хэрэгжүүлэх үндэсний мэргэжилтэнг бэлтгэх	- 200.0	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлийн чанарыг сайжруулах, өргөжүүлэх ажлын хүрээнд хөлөг онгоцыг алсын зайнаас хянах /LRIT/ системд холбогдох туршилтын ажил хийгдэж дууссан. - Олон улсын хиймэл дагуулын байгууллагын /IMSO/ системд албан ёсоор холбогдож, хөлөг онгоцны бүртгэл хариуцсан ажилтнууд системийн программд нэвтрэх эрх аваад байна. - Монгол Улсын Үндэсний Дата төвийг бүрэн ажиллагаанд оруулах, хөлөг онгоцыг алсын зайнаас хянах системийн нийцлийн туршилтыг хийх зорилгоор Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй болон шинээр бүртгүүлж буй хөлөг онгоц эзэмшигчдэд оператортай холбогдож нийцлийн туршилт (conformance test) хийлгүүлэх мэдэгдлийг хүргүүлээд байна. "ОУДБ-ын "Хөлөг онгоцонд техникийн үзлэг шалгалт хийх хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага"-ын журмын дагуу Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцонд хяналт шалгалт хийх хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагатай хийх гэрээг боловсруулан яамны холбогдох газруудаас санал авч, тусган ажиллаж байна. БНСУ-ын Пусан боомтод байрлах "Searoad Shipping and Agency" компанитай хөлөг онгоц бүртгэлийн агентын гэрээг үзэглэн тохиролцсон бөгөөд Зам тээврийн хөгжлийн сайдын чиглэлийн дагуу хөлөг онгоц бүртгэлийн агентын нээлттэй сонгон шалгаруулалт явуулахаар ажиллаж байна. 	
61		3. Байгаль орчинд ээлтэй усан замын тээврийг хөгжүүлэхэд анхаарч төрийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэд хоорондын уялдаа холбоог сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2017-2020	-	-	Хууль батлагдах Дагалдах дүрэм, журам батлагдах	-	<p>ТЗДТБХЗГ, "Далайн захиргаа" УТҮГ:</p> <p>Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн найруулан боловсруулж УИХ-ын нэгдсэн чуулганы 2017 оны 05 дугаар сарын 25--ны өдрийн хуралдаанд хэлэлцүүлж батлуулав. Шинэчилсэн хууль 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.</p> <p>Хууль шинэчлэн батлагдсанаар дагалдан гарах усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм болон техникийн шаардлагын төслүүдийг боловсруулж, хувийн хэвшил, төрийн байгууллагууд, иргэдийн дунд цахимаар болон биетээр хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг нь тусган ажиллаж байна.</p>	40%

62		4. Хөвсгөл нуурт усан замын төв зогсоол, дэд бүтцийг хөгжүүлж, аюулгүй, байгаль орчинд ээлтэй усан замын тээврийн үйл ажиллагааг сайжруулах	2016-2020	Төр, хувийн хэвшлийн түншлэл	4 250,0	Концессын сөнгөн шалгаруулалт зарлах Шалгарсан хуулийн этгээд, ААН-тай Концессын гэрээ байгуулах, ТЭЗҮ-ийг боловсруулах	- 250.0	<p>ТЗДТБХЗГ, “Далайн захиргаа” УТҮГ:</p> <ul style="list-style-type: none"> - Усан замын тээврийн хэрэгслийн нэгдсэн зогсоол бүхий зорчигч үйлчилгээний төв буудлыг Хөвсгөл нуурын эрэгт барьж байгуулах асуудлыг концессын гэрээгээр шийдвэрлүүлэхээр ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоол, түүний хавсралтаар батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтын 1 дэх хэсгийн 7⁴ дэх заалтад ЗГ-ын 2015 оны 133 дугаар тогтоолоор нэмэлт оруулж тусгасан. - Усан замын төв буудал барих газрыг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 1/542 тоот, Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн А/16 тоот захирамж, Хатгал тосгоны захирагчийн 2017 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 1/71 тоот захирамжаар тус тус шийдвэрлүүлж, газар зүйн солбицол, координатыг нь тогтоолгосон. - “Усан замын төв буудал” барих ажлын даалгаврын төслийг боловсруулж, холбогдох төрийн байгууллага, аймаг, орон нутгаас санал авч концесс зарлах тухай ТНБД-ын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 03/5520 тоот албан бичгийг ажлын даалгавар, газар шийдвэрлэсэн нутгийн захиргааны байгууллагын шийдвэрийн хамт Үндэсний хөгжлийн газарт хүргүүлээд байна <p>Тус газраас концесс зарлахаар байгуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж байгаа болно. Энэхүү төв буудал нь Хөвсгөл нуурын усан замын дэд бүтцийн томоохон цогцолбор болох ба ингэснээр байгаль орчинд ээлтэй, аюулгүй усан замын тээврийн үйл ажиллагаа сайжирна.</p>	40%
63	2.118. Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ.	1.Төмөр замын зорчигч, ачаа тээврийн үйлчилгээнд орчин үеийн менежментийн аргуудыг бий болгох, үйлчилгээний чанарыг сайжруулах	2016-2020	-	-	-	-	<p>ТЗДТБХЗГ, “УБТЗ” ХНН: 2016 онд: “УБТЗ” ХНН-ийн харьяа “Улаанбаатар дахь зорчигчийн вагон депо”-ийн 482 дугаар вагоныг техникийн зураг, төслийн дагуу сэргээгдэх их засварыг хийж, тусгай зориулалтын вагон болгох хийцийг өөрчлөн тоноглон, туршилтын аяллаар шалгаж №16001, код-О-4-2, РД:2076675 дугаар бүхий “Аюулгүй ажиллагаа”-ны гэрчилгээг олгосон. Тус вагоныг 2016.05.20-ны өдрөөс эхлэн 7 хоногт 2 удаа байнгын тээвэрлэлтэд ашиглаж “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд”-ийг төмөр замаар аюулгүй, ая тухтай зорчих, зорчигч үйлчилгээний стандартын шаардлагыг хангаж ажилласан.</p> <p>Төмөр замын объектыг коджуулах тухай О 920-2, О+920; О+920-1,2; О+914 санамжуудыг MNS 920; MNS920-1,2; MNS914 стандарт болгон батлуулахаар ажиллаж байна.</p> <p>2017 онд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 16 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг “Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм”-ийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 541 дүгээр тушаалаар шинэчлэн батлуулав. 2. Сэлэнгэ, Сайншанд, Замын-Үүдийн төмөр замын буудлын авто тээврийн тасалбар түгээгүүрийг байрлуулж, буудлуудын ашиглалт болон иргэдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулав. 	70%

							<p>3. Зорчигчид үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн галт тэрэгний аяллын хугацааг 9 цагаар богиносгож, 7 хоногт тогтмол аялах галт тэрэгний тоог нэмэгдүүлэв.</p> <p>4. Олон улсын галт тэргээр зорчигч тээвэрлэх үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор 2017.07.30-08.04-ний өдрүүдэд ОХУ-ын Москва хотноо Төмөр замын тээврийн судалгаа шинжилгээний хүрээлэнтэй хамтран Монгол Улс, Оросын Холбооны Улсын төмөр замаар зорчигчийн галт тэргэнд тасалбар худалдаалах цахим програмыг харилцан уялдуулах чиглэлээр хамтарсан судалгааг эхлүүлэн, тооцоо судалгааг хийж байна.</p> <p>5. Түүнчлэн тээвэр зуучлалын үйл ажиллагааны чанарыг сайжруулах тулгамдаад буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Тээвэр зуучлалын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын төлөөлөлтэй 2017.08.11-ний өдөр уулзалт зохион байгуулж, харилцан санал солилцов. Гэрчилгээжүүлэлтийн журамд тээвэр зуучлалын үйл ажиллагаатай холбоотой аюулгүй байдлын гэрчилгээ олгоход тавигдах шаардлагыг өөрчлөн, сайжруулж, төслийг бэлэн болгоод байна.</p> <p>Мөн галт тэрэгний тасалбар худалдаалалтыг бүрэн цахимжуулж бүх банкны картыг ашиглан цахимаар тасалбар худалдан авах боломжтой болгосон. Зорчигчдын тав тухыг хангах зорилгоор Улаанбаатар-Сайншанд чиглэлийн галт тэрэгний цагийн хуваарийг 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн цагийн хуваарьт өөрчлөлт оруулсан.</p>	
64	2.Аюулгүй, найдвартай, их багтаамжийн нийтийн тээврийг хөгжүүлэн 400-аас доошгүй автобусаар парк шинэчлэх	2016-2020	Улсын төсөв, гадаад эх үүсвэр	80 000,0	400 автобус авах 100 автобус авах	20 000,0 2017 онд зарцуулсан - 20,000.0	<p>АТБХЗГ: 2017 онд: МУ-ын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд авах зээлийн хөрөнгөөр “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлж байна. МУ-ын Засгийн газрыг төлөөлж Сангийн яам, БНСУ-ын Засгийн газраас “ЭЗХХАС”-гийн үйл ажиллагаа болон удирдлагыг итгэмжилсэн Эксим банкны хооронд гэрээ байгуулсан. Эхний шатны төслийн хүрээнд улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглах 43 автобусыг 5.5 сая ам.долларын санхүүжилтээр худалдан авч хэрэгжүүлсэн.</p> <p>Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн хоёрдугаар шатны төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Сангийн яам, БНСУ-ын Экспорт-импорт банкны хооронд зээлийн гэрээг 2016 оны 07 дугаар сарын 17-ны өдөр байгуулсан бөгөөд энэхүү төсөлд автобус худалдан авах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр тусгасан. Энэхүү төслөөр улс, хот хооронд болон жуулчин тээврийн үйлчилгээнд 189 автобус авах бөгөөд автобусны үнэ өнөөгийн валютын ханшны үнээр тооцоход өндөр гарч байгаагаас тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгжүүд төсөлд хамрагдахаас татгалзаж байгаа тул цаашид төслийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй болж байна. Төслийг нийслэлд хэрэгжүүлэх талаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн гаргасан саналыг үндэслэн хотын нийтийн тээврийн үйлчилгээнд бүрэн ашиглах зориулалтаар санал дэвшүүлсэн.</p>	-

							<p>2018 онд: Эксим банкны 2 дугаар шатны төслийн зориулалтыг “Нийслэл хотын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл” болгон өөрчлөх асуудлаар Зам, тээврийн хөгжлийн сайдын Зөвлөлийн хурлаар хэлэлцэж, дэмжигдсэн бөгөөд энэхүү шийдвэрийг үндэслэн Сангийн сайдад хандан 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01/152 тоот албан бичгээр хүргүүлэв. Сангийн яам тус яамны хүсэлтийг БНСУ-ын Эксим банкид уламжилсан бөгөөд зориулалтыг өөрчлөхийг зөвшөөрөөгүй. Иймд Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын ерөнхий хэлэлцээрийн хүрээнд авах зээлийн хөрөнгөөр “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн эхний шатны төслийн хэрэгжилтийн тухай болон хоёрдугаар шатны төслийн талаар цаашид авах арга хэмжээний тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулахаар хуралдааны тэмдэглэл болон тогтоолын төсөл, танилцуулгын хамт 2018 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн 01/1186 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлэв.</p> <p>Агаарын бохирдлыг бууруулах зорилтын хүрээнд нийслэл хотын нийтийн тээврийн хэрэгслийг цахилгаан болон хийн түлшний хэрэглээнд шилжүүлэх зорилгоор “Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-ийг дуусгавар болгож, 2 дугаар шатанд хэрэгжүүлэх 25.0 сая.ам.долларын санхүүжилтыг “Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төсөл”-д зориулах нь зүйтэй гэж үзэж, тусгайлсан зээлийн гэрээг БНСУ-ын Эксим банктai шинэчлэн байгуулах саналыг Засгийн газрын хуралдаанд оруулахаар ажиллаж байна. Аюулгүй, найдвартай, их багтаамжийн автобусаар нийтийн тээврийг хөгжүүлэхэд тээвэрлэлт гүйцэтгэж буй аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн нөөц хөрөнгийг бүрдүүлэн идэвхтэй ажиллаж байгаа ба 2017 онд үйлдвэрлэснээс хойш 4-7 жил ашигласан буюу насжилттай 141 автобусыг импортоор оруулж, үйлчилгээнд ашигласан бол 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар 2014-2016 онд үйлдвэрлэсэн 102 автобусыг импортоор авч, үйлчилгээнд ажиллуулж байна.</p>		
65		3.Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн нэгдсэн систем бүрдүүлэх	2017-2018	-	-	Мэдээллийн нэгдсэн системийг бүрдүүлэх	-	<p>БТГ: Үндэсний статистикийн хороотой хамтран зам, тээврийн салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн систем хийх ажлын бэлтгэл ажлыг зохион байгуулж байна. Зам, тээврийн сайдын 2017 оны 91 дүгээр тушаалаар “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан “Зам, тээврийн салбарын статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн нэгдсэн систем бүрдүүлэх” ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Ажлын хэсгийн хурал 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хуралдсан бөгөөд ажлын төлөвлөгөө, салбарын статистикийн өнөөгийн байдлын талаар хэлэлцэж, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцэж шийдвэрлэсэн.</p>	70%

							Салбар салбарын төлөөллүүд тусдаа уулзалт зохион байгуулж эхний шатанд нэгдсэн системд оруулах статистик мэдээллүүдийн маягтыг тохиролцсон. Автотээврийн болон усан замын тээврийн маягтуудыг Үндэсний статистикийн хорооны зөвшөөрлөөр Зам, тээврийн сайдын 2017 оны 08 сарын 08-ны өдрийн 157, 158 дугаар тушаалаар батлуулав. Статистик мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн бүртгэлийн нэгдсэн системийн програмчлалын боловсруулалт хийгдэж тест хувилбар гарсан. Уг програмыг байршуулах www.statistic.mrtd.gov.mn домэйн хаягийг шинээр нээв. Програмын тест хувилбарыг гаргаж, харьяа байгууллагуудын холбогдох хүмүүст програмын эрх өгч мэдээллийг оруулж байна.		
66		4.Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бүрдүүлэх	2017-2018	Гадаад зээл	2 100,0	Судалгааны ажлын хийгдэх Төсөл хэрэгжих	1 000,0 2017 онд зарцуулсан - 1,100.0	<p>АТБХЗГ: Замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог бий болгох, холбогдох эрх зүйн орчинг бүрдүүлэх судалгааны ажлыг хийж дуусган, ЗТХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2016.12.19-ний өдрийн 02 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн авто замын салбарт хяналт, шалгалт хийх чиглэлээр мөрдөж буй 5 журамтай уялдуулан боловсруулсны дараа хүлээн авахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу:</p> <ol style="list-style-type: none"> 1. Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ; 2. Замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлүүдэд хийсэн дүн шинжилгээ; 3. Хөдөлгөөн зохион байгуулалтын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ; 4. Монгол улсын авто замын төлөвлөлтийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ; 5. Авто замын тээврийн салбарт мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичиг болон хөгжлийн бодлогод хийсэн дүн шинжилгээ; 6. Авто замын төлөвлөлт ба хөдөлгөөний аюулгүй байдлын талаарх гадаад улс орны тэргүүн туршлага судалгаа; 7. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит (ЗХАБА-ын тухай ерөнхий ойлголт, түүний хэрэгцээ, шаардлага, ач холбогдол, гадаад улс орнуудын туршлага зэргийг хамарсан судалгаа), авто замын төлөвлөлт болох хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаарх бусад орны туршлага, харьцуулалт зэргийг хамарсан)талаарх судалгаа; 8. Монгол Улсад замын хөдөлгөөний аюулгүй байдалд аудит хийх тогтолцоог нэвтрүүлэх аргачлал, зөвлөмж (эрх зүйн орчинг бүрдүүлэх хүрээнд хуулийн төсөл, журмын төсөл, аргачлалын төслийг, практик хэрэглээнд нэвтрүүлэх хүрээнд загвар тайланг)-ийг тус тус боловсруулсан. Уг ажлын хүрээнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах компани ажил” сэдэвт семинарыг 2017 оны 9 сарын 13-ны өдөр Улаанбаатар зочид буудалд зохион байгуулав. <p>Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны санхүүжилтээр “Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах” ТА 9137-MON төслийг 2017 оны 04 дүгээр</p>	70%

								сараас эхлүүлсэн бөгөөд Энэхүү төслийн хүрээнд “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын аудит хийх аргачлал” боловсруулан ЗТХЯ-ны ХШҮДАГ-т хүлээлгэн өгөв. БНСУ, Дани улсын замын хөдөлгөөний аудит хийж байгаа тогтолцоотой танилцаж боловсруулсан аргачлалыг шинэчлэн ЗТХ-ийн сайдаар батлуулахаар төлөвлөөд байна.	
67		5.Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, татвар, даатгал, авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх	2016-2020	Гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	2 700,0	Хөдөлгөөний эрчмийн тооллого хийх цэгүүдэд RFID системийг суурьлуулж эхлэх	700.0	АТБХЗГ: Улаанбаатар хотын орох, гарах хяналтын цэгүүдэд RFID-д суурилсан системийг суурилуулах туршилтын ажлыг “Гашуун сухайт авто зам” ХХК болон “АТУТ” ТӨҮГ-тай хамтарч эхлүүлэхээр болсон. Мөн “Гашуун-Сухайн авто зам” ХХК-ийн төлбөр хураах цэг дээр туршилт явуулахаар RFID уншигч төхөөрөмж, програм хангамжийг хүлээлгэн өгсөн. Мөн Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Албан журмын даатгуулагчдын холбоотой хамтран Монгол Улсад бүртгэлтэй байгаа нийт тээврийн хэрэгсэлд RFID-д системийг ашиглан хяналт хийх талаар уулзалт зохион байгуулсан. RFID-д суурилан хэрхэн хяналт хийж, цахимжуулах талаар танилцуулга хийгдсэн. “Авто замын цахим төлбөр хураах систем” төслийн санал боловсруулж БНСУ-ын техникийн туслалцааны хүрээнд хэрэгжүүлэх хүсэлтийг Сангийн яам болон БНСУ-ын тээврийн яаманд 2018 оны 01/1203 тоот албан бичгээр гаргаж төслийн товч мэдээллийн хамт хүргүүлэв. Уг төсөлд авто үйлчилгээний салбарт RFID системийг нэвтрүүлэх талаар тусгагдсан болно.	40%
68		6.Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх ажлыг зохион байгуулах	2016-2017	Гадаад эх үүсвэр	1 065,0	Төсөл хэрэгжих	1 065,0 2017 онд зарцуулсан -	АТБХЗГ: 2017 онд: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Монгол Улсын Тээврийн ухаалаг системийн бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ТА-9131 МОН” техникийн туслалцааны төслийг 2017 оны 03 дугаар сарын 17-ноос эхлүүлсэн. Энэхүү төслийн гүйцэтгэгчээр БНСУ-ын Тээврийн хүрээлэн шалгаран ажиллаж байгаа бөгөөд нэг жилийн хугацаатай үргэлжилнэ. Уг төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэнэ. Үүнд: - Үндэсний ухаалаг тээврийн системийн бодлого болон стратеги төлөвлөгөө боловсруулах. - Ухаалаг тээврийн системийн оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх. - Мэдлэгт суурилсан бүтээгдэхүүнийг түгээх. - “Тархай хөгжсөн улс, орнуудын ухаалаг тээврийн системийн бодлого, стратеги төлөвлөгөө: Монгол улсын жишээн дээр” ном хэвлэгдэн гарч олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулна. Төслийн Удирдах хороо байгуулагдан ажиллаж байна. Төслийн график төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхлэлийн шатны тайлан, дундын тайланг хүлээлгэн өгөөд байна. 2018 онд: Төслийн график төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхлэлийн шатны тайлан, дундын тайланг хүлээлгэн өгсөн. АТБХЗГ-ын 2017 оны 07/4885 тоот албан бичгээр холбогдох төрийн байгууллагуудаас Тээврийн ухаалаг системийг эрэмбэлэх ажилд санал авч 2018 оны 01 дүгээр сарын 18-нд Тээврийн ухаалаг системийг эрэмбэлэх ажлын	40%

							хэлэлцүүлэгийг зохион байгуулсан. Тээврийн ухаалаг системийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам"-д заасны дагуу судалгаа, тайланг боловсруулж ирүүлэхийг Төслийн багийнханд 2018 оны 07/791 тоот албан бичгээр мэдэгдсэн.		
69		7.Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2016-2020	Зам, тээврийн салбарын нормчлолын сан	4 000,0	Хөтөлбөр боловсруулаж Хөтөлбөрийн хүрээнд зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичиг боловсронгуй болох	1 000,0 2017 онд зарцуулсан 323,0 1,000.0	БТГ: "Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сан"-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, тус сангийн Удирдах зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Холбогдох ажлын даалгавруудыг боловсруулж байна. Авто тээвэр(ТХ15), авто зам(ТХ15/ДХ01), төмөр зам, далай ашиглалт, усан тээвэр(ТХ33), иргэний нисэх(ТХ34) стандартчиллын техникийн хороодын 2017-2018 оны стандартчиллын ажлын хөтөлбөр, төлөвлөгөөг Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 01 дүгээр тогтоолоор батлууллаа. Дээрх техникийн хороодын үйл ажиллагаатай уялдуулан "Зам, тээврийн салбарын стандарт, техникийн баримт бичгийг боловсронгуй болгох хөтөлбөр"-ийн төслийг боловсруулж Зам, тээврийн салбарын норматив баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн удирдах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 121 дүгээр тушаалаар батлуулав. Зам, тээврийн салбарын норматив, баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн 2018-2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018.03.06-ны өдөр Төрийн нарийн бичгийн дарга болон Сангийн удирдах зөвлөлийн даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70%
70	2.119. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан автозамын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонсголонгий	3.Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэл хийх	2017-2019	Гадаад зээл	73 620,0	Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь	8 180,0 2017 онд зарцуулсан - 24,540.0	АЗБХЗГ: 2017 онд: Тус төслийг Засгийн газрын 2015 оны 458 тогтоолоор төслийн ажлыг зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төслийн гүйцэтгэгч "Синохайдро корпораци лимитед" компанитай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр барилгын ажлын гэрээ, 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр "Гуанжоу Ванан Констракшн Супервишн" ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. /Төслийн нийт өртөг 38,2 сая ам.доллар. Хэрэгжүүлэх хугацаа 24 сар/ Захиалагчийн зүгээс Баянзүрхийн товчоо орчмын газар чөлөөлөлтийн нөлөөлөл ихтэй авто замын трассыг өөрчлөхөөр шийдвэрлэсний дагуу зургийн зөвлөх компани замын трассын эхний 5км-т өөрчлөлт оруулан зураг төслийг боловсруулж дууссан. Нийслэлийн ГА-аас 09 дүгээр сарын 25-ны өдөр төслийн газар чөлөөлөлтийн ажлыг бүрэн хэрэгжүүлж дууссан.	0

	н гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барина.							Нийслэлийн ЗД-ын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/617 захирамжаар 3 байршилд авто замын барилгын ажилд ашиглах карьерын зөвшөөрөл олгосон. ЗГ-ын 2017 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 222 дугаар тогтоолоор төслийн Монголын талын хариуцах зардал 15%-ийг 5% болгон өөрчлөн баталсан. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулж, БОАЖЯ-нд хүргүүлсэн. Хятадын Эксим банк, Сангийн яам хооронд тусгайлсан зээлийн гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. 2018 онд: -	
71	4.Туул гол дээгүүрх Баянзүрхийн 288 урт метр болон Сонсголонгийн 289.4 урт метр төмөр бетон гүүрийг барих	2017-2019	Гадаад зээл	40 635,0	Барилгын ажлын гүйцэтгэл 40 хувь	4 515,0 2017 онд зарцуулсан - 13,545.0	АЗБХЗГ: 2017 онд: Тус төслийг Засгийн газрын 2015 оны 309 тогтоолоор хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төслийн гүйцэтгэгч Бээжин Юни-Констракшн Групп компанитай 2016 оны 07 дүгээр сарын 18-ны өдөр барилгын ажлын гэрээг, 2017 оны 4 сарын 17-ны өдөр "Гуанжоу Ванан Констракшн Супервишн" ХХК-тай хяналтын зөвлөх үйлчилгээний гэрээг тус тус байгуулсан. /Төслийн нийт өртөг 21,4 сая ам.доллар, хэрэгжүүлэх хугацаа 22 сар/ Төслийн хүрээнд одоо байгаа Сонсголонгийн гүүртэй параллелиар 2 эгнээ гүүр шинээр барих ба Налайх чиглэлийн авто замын трассын дагуу Баянзүрхийн гүүрийн ойролцоо шинээр 4 эгнээ гүүрийн барилга угсралтын ажил хийгдэнэ. Газар чөлөөлөлтийн ажлыг багасгах үүднээс Налайх чиглэлийн авто зам болон Баянзүрхийн гүүрийн зураг төсөлд өөрчлөлт оруулж дууссан. Хятадын Эксим банк, МУ-ын Сангийн яам хооронд 2017 оны 50 дугаар сарын 12-ны өдөр байгуулагдсан төслийн тусгайлсан зээлийн гэрээ 10 дугаар сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 2018 онд: Хятадын Эксим банкнаас төслийн урьдчилгаа төлбөрийг шийдвэрлэснээр, барилгын ажлыг 2018 оны 4 дүгээр сард эхлүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна.	40%	
72	Яармагийн гүүрийг засварлан, улмаар шинээр параллель гүүр, нүхэн гарц барих замаар олон түвшний огтлолыг бий болгох, 360 урт метр гүүр, 40 урт метр	2018-2020	Гадаад зээл, төр, хувийн хэвшлийн түншлэл	46,177.0	Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь	4,617.7	БТГ: Яармагийн гүүрийг засварлан, 240 у/м төмөр бетон гүүр шинээр барих, 50 урт метр нүхэн гарц барих ажил 2016 онд эхэлсэн. Гүйцэтгэгчээр нь БНХАУ-ын "Төмөр замын 2-р групп" ХХК ажиллаж байна. 2018 оны 1-р улирлын байдлаар ажлын явц нь 30% -тай байна. Гэрээний дагуу 2019 оны 1-р улиралд багтаан ашиглалтад өгөхөөр ажилаж байна.	70%	

		нүхэн гарц барих							
73	2.120. Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ.	1.Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх	2016-2020	Гадаад эх үүсвэр	310 500,0	Төслийн нэгжийг байгуулах ТЭЗҮ боловсруулагдах	5 000,0 2017 онд зарцуулсан - 10,000.0	АТБХЗГ: Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр BRT /тусгай замын автобус/ төслийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Төслийн удирдах хороог Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 18 дугаар тогтоолоор шинэчлэн батлав. Төслийн удирдах хороо 2017 оны 1 дүгээр сард НЗД-ын захирамжаар шинэчлэн байгуулагдсан ба төсөл хэрэгжүүлэх нэгжийн удирдлагыг сонгон шалгаруулсан. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн баг сонгон шалгаруулалтаар бүрдсэн бөгөөд нэгжийн 2017-2018 оны хийх ажлын төлөвлөгөөг Төслийн удирдах хороо баталсан байна. Энэхүү төслийн эхний үе шатанд тусгай замын автобусны авто замын трассыг тогтоох, зураг төслийг боловсруулах зөвлөх багийг сонгон шалгаруулах тендер зарласан. Тусгай замын автобусны авто зам түүний дэд бүтцийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ шалгаруулах олон улсын тендерийг 2017 оны 10 дугаар сарын 26-наас 11 сарын 24-ний өдрийн хооронд зарласан. Уг тендэрт оролцох сонирхлыг 20 компани илэрхийлсэн бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 13-ны байдлаар үнэлгээний хороо хураангуй жагсаалтаар нийт 6 компанийг шалгаруулсан ба богино жагсаалтаар шалгарах аж ахуйн нэгжийг 2018 оны 05 дугаар сарын 10-ны дотор шалгаруулж, гэрээ байгуулна. Зөвлөх баг нь 3 үе шаттайгаар зураг төслийн ажлыг хийх бөгөөд 2018 оны 11-12 дугаар сард эхний зураг төслөөр хийх барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулна. Төлөвлөгөөгөөр 2019 оны 05 дугаар сард эхний үе шатны барилгын ажил эхэлнэ. GEF MON-0315 буюу төслийн бүрэлдэхүүн хэсэг Дэлхийн байгаль орчны сангийн 1,5 сая ам долларын буцалтгүй тусламжийн хүрээнд хийгдэх зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврын төслийг эцэслэж НЗДТГ-аас санал авахаар ажиллаж байна. Улаанбаатар хоттой ойролцоо бусад орны хотуудад ТЗА-ны төсөл хэрэгжсэн Study tour буюу туршлага судлах аяллыг Казакстан улсын Алма-Ата, БНХАУ-ын Ичанг хотуудад 2018 оны 03 сарын 03-11 хооронд зохион байгуулсан.	40%
74	2.121. Автозамын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе	1.Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээний бэлэн байдлыг жилийн туршид хангах, арчлалт, засварын	2016-2020	Улсын төсөв	189 810,0	Арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх	39 310,0 22 000,0 төсөвт сууснаас 21 990,0 сая төг	АЗБХЗГ: Улсын төсөвт олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжийн арчлалт, засварын ажилд 20.0 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд замын чиглэл, хариуцагч компани бүрээр хучилтын төрөл, насжилт, хөдөлгөөний эрчимтэй уялдуулан 2018 оны төлөвлөгөөг гаргаж, Зам, тээврийн хөгжлийн сайдын 38 дугаар тушаалаар батлуулан төрийн өмчит 20, хувийн хэвшлийн 7, нийт 27 зам хариуцагч компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Сайдын тушаалаар батлагдсан нийт 48 цэгт өвлийн арчлалтын “Шуурхай ажлын хэсэг” гарч Олон улсын болон улсын чанартай 12967 км авто зам,	40%

	шаттай нэмэгдүүлнэ.	ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэх					48,000.0	замын байгууламжийн өдөр тутмын байнгын бэлэн байдлыг ханган ажиллаж байна.	
75		2.Улаанбаатар-Дархан-Алтанбулаг, Улаанбаатар-Арвайхээр, Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Чингис, Налайх-Чингис чиглэлийн нийт 504 км авто замд их засвар шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэх	2016-2020	Улсын төсөв	226 800,0	126 км авто замд их засвар, шинэчлэлийн ажил хийж гүйцэтгэх 252 км авто замд их засвар, шинэчлэлийн ажил хийж гүйцэтгэх	56 700,0 2017 онд зарцуулсан - 56,700.0	АЗБХЗГ: 2017 онд: Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2016 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км, Элсэнтасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км нийт 107.2 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажлыг Улсын ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Жаргалтхаан-Чингис хот чиглэлийн 100 км авто замын 1-р ээлжийн 17 км авто замын их засварын ажлыг “Наранбулаг хан” ХХК, “Анандын зам” ХХК-ийн түншлэлээр гүйцэтгүүлж, 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр улсын ашиглалтад оруулсан. Улаанбаатар-Дархан чиглэлийн 205 км авто замыг тусгаарлах зурвас, 4 эгнээ бүхий 1 дүгээр ангиллын авто зам болгон шинэчлэх ажлын зураг төслийг боловсруулж дууссан. Шинэчлэлтийн ажлыг 2018 онд эхлүүлнэ. Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 4.5 км авто замын шинэчлэлтийн ажлыг 2.223 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр “Жол” ХХК гэрээ байгуулан ажиллаж, нийт ажлын 65%-ийг гүйцэтгэж, 2017 онд батлагдсан хөрөнгийг зарцуулсан. 2018 оны 07 дугаар сард багтааж ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Гэрээний хугацаа 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдөр дуусна. Ховд аймгийн Жаргалант сумын 3.784 км авто замын шинэчлэлтийн ажлыг 2.29 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр “Түмдэлгэрэх” ХХК 2017 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж, нийт ажлын 55%-ийг гүйцэтгэж, 2017 онд батлагдсан хөрөнгийг бүрэн зарцуулсан. Гэрээний хугацаагаар 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгнө. 2018 онд: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймгийн төвийн 10.4 км авто замын их засвар, шинэчлэлтийн ажил хийгдэж эхэлнэ. Тендер зарласан. Азийн хөгжлийн банкны 60.0 сая долларын санхүүжилтээр АН-3 чиглэлийн олон улсын чанартай Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замд их засвар, шинэчлэлтийн ажлыг гүйцэтгэхээр шийдвэрлээд байна.	
76		3.Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Арвайхээр, Улаанбаатар-Чингис, Налайх-Чойр,	2016-2020	Улсын төсөв	145 000,0	181 км авто замд ээлжит засварын ажлыг хийж гүйцэтгэх	36 250,0 2017 онд зарцуулсан -	АЗБХЗГ: 2017 онд: Улсын төсвийн төсөлд УБ-Арвайхээр чиглэлийн 62 км, УБ-Чойр чиглэлийн 59 км, УБ-Дархан чиглэлийн 64 км авто замд ээлжит засвар хийх санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдэгдээгүй.	

		Хархорин-Цэцэрлэг, Улаангом-Хандгайт, Өлгий-Улаан байшинт чиглэлийн 725 км авто замд ээлжит засварын ажлыг гүйцэтгэх				362 км авто замд ээлжит засварын ажлыг хийж гүйцэтгэх	36,250.0	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Улаанбаатар-Дархан А0401 чиглэлийн авто замын 196-202 дахь км буюу 6 км авто замын ээлжит засварын ажлыг “Дархан АЗЗА” ТӨХК гүйцэтгэж, 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн. 2018 онд: Хөрөнгө оруулалт, санхүүжилт шийдэгдэхгүй байгаагаас ээлжит болон их засварын ажил хугацаандаа хийгдэхгүй байна.	
77		4.Чигэстэй, Онги, Түргэн, Цалгар, Усан хоолой, Цагаан сүм, Тэс, Хэрлэн, Буянт, Хуурай хөндий, Хараагийн нийт 1128.5 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар шинэчлэлийн ажил хийх	2016-2020	Улсын төсөв	16 400,0	282.1 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар шинэчлэлийн ажил хийж гүйцэтгэх 564.2 урт метр төмөр бетон гүүрэнд их засвар шинэчлэлийн ажил хийж гүйцэтгэх	4 100,0 2017 онд зарцуулсан - 4,100.0	АЗБХЗГ: 2016 онд: Улсын чанартай авто замын урсгал засвар, арчлалтын ажлын хөрөнгөөр Чигэстэй голын 54 у/м , Цагаан сүмийн 51 у/м гүүрэнд засварын ажлыг хийж дуусгасан. 2017 онд: Архангай аймгийн Тариат сумын Тэрхийн голын 217.1 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлыг 3.152 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Хурдны зам” ХХК гэрээ байгуулан гүйцэтгэж дууссан. Их засварын ажлыг ашиглалтад оруулах комисс ажиллахаар болоод байна. Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замд байрлах Тарнын голын 48.2 у/м төмөр бетон гүүр үерийн улмаас гэнэтийн эвдрэл гарч нурсан тул 2017 оны урсгал засвар арчлалтын ажлын хөрөнгөөр засварлаж, ашиглалтад оруулсан. Нийт 370.3 у/м гүүрэнд засварын ажил хийсэн. 2017 оны урсгал засвар, арчлалтын хөрөнгөнөөс 55.0 сая төгрөгөөр Алтай-Ховд чиглэлийн авто замд байрлах Ээвийн голын 24 у/м төмөр бетон гүүрийн их засварын ажлын зураг төслийг боловсруулсан. 2018 онд: Увс аймгийн Цалгарын голын 126.8 у/м, Баян-Өлгийн аймгийн Сагсайн голын 96.8 у/м гүүрэнд ээлжит засвар, Увс аймгийн Гашууны голын 90у/м, Дархан-Уул аймгийн Хараа голын 135 у/м, Хэнтий аймгийн Дадал сумын Онон голын 238.9 у/м гүүрэнд их засварын ажил тус тус гүйцэтгэнэ.	-
Тэргүүлэх зорилт №3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.									
78	3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж,	6. Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгууллагатай болох ажлыг эхлүүлэх	2017-2019	Улсын төсөв, гадаад эх үүсвэр, төр, хувийн хэвшлийн түншлэл	10 000,0	Судалгааны ажил хийгдэх Эрдэм шинжилгээ судалгааны байгуулл	6 000,0 2017 онд зарцуулсан - 4,000.0	БТГ: БСШУСЯ-ын захиалгаар хэрэгжсэн “Судалгаа хөгжлийн ажлын асуулга зохион байгуулах” судалгааны ажилд хамтран оролцож, төрийн байгууллагууд тухайлбал зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны ажлын талаар судалгаа хийсэн. Уг судалгаанд үндэслэн дараах эрх зүйн орчинг бүрдүүлж харьяа газар, байгууллагуудын эрдэм шинжилгээ, судалгааны нэгжүүд байгуулах асуудлыг шийдвэрлүүлсэн. Үүнд: - 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар батлагдсан Авто замын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 9 дүгээр зүйлийн 9.1.6 дахь заалтад буюу Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн	40%

	лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.					агатай болох холбогдох шийдвэр гаргуулах		хүрээнд “авто замын засвар, арчлалт, хамгаалалт, ашиглалтын нэгдсэн зохион байгуулалтаар ханган эрдэм, шинжилгээ судалгааны ажил хийж, замын стандарт, норматив, техник технологийг сайжруулах үүрэг бүхий авто замын судалгаа, шинжилгээний байгууллага ажиллуулах” гэж оруулан эрх зүйн орчинг бий болгоод байна. - Төрийн өмчийн хорооны 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ын бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн “Судалгаа, хөгжил, чанар удирдлагын алба”-тай байхаар оруулан батлуулав. Авто замын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу Авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагатай болох асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар судалж, санал боловсруулж байна.	
79		7. Авто замын салбарт дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цемент ашиглан цемент бетон хучилттай авто зам барьж, өртөг зардал хямд авто замын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, үндэсний стандартыг бий болгох	2016-2020	Гадаад эх үүсвэр	50 000,0	Дотоодын бүтээгдэхүүн, цементээр бетон хучилттай авто зам барих технологи бүхий зам барьж турших	10 000,0 2017 онд зарцуулсан Дотоодоос 53,3 сая төг 20,000.0	БТГ: Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, цементээр бетон хучилттай авто зам барих, замын өртөг зардлыг бууруулах, ашиглалтын чанарыг сайжруулах, техник технологийг боловсруулах, судалгааны ажлыг “МСРС” ХХК-тай гэрээ байгуулан, гүйцэтгүүлсэн. Тус судалгааны ажлын эцсийн тайланг хүлээн авч, Зам, тээврийн салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн Улаанбаатар-Дарханы чиглэлийн замын их засвар шинэчлэлтийг цементобетон хучилттай хийх зураг төслийн ажлын даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан инженерийн нарийвчилсан зураг төслийг боловсруулж дуусгаад байна. Уг зураг төслийн хүрээнд авто замын хучилтын төсвийг асфальтобетонтой харьцуулахад цементобетон хучилттай зам барих төсөвт өртөг хямд гарч байна. Авто замын салбарт цементобетон хучилтыг хэрэглэх туршилтыг хийлгэх Техник туслалцааг Япон Улсын Нийгата муж дахь Судалгааны хүрээлэнгээр хийлгэхээр санал хүргүүлсэн дагуу 2018 оны 03 сарын 06-нд Нийгата мужийн өргөмжлөлт консулын дэргэдэх Технологи дамжуулах Зөвлөлдөх хороо хуралдсан ба уг зөвлөлдөх хороо өмнөх жилүүдэд авто замын салбарт ЖАЙКА байгууллагаас хэрэгжүүлж байсан технологи дамжуулах төслүүдийн талаархи мэдээллүүдийг аваад байна.	40%
Тэргүүлэх зорилт №4.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.									
80	4.1.3. Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль	1.Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох, хариуцлага, хяналтын	2017-2020	-	-	Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийг боловсронгуй	- 2017 онд зарцуулсан 10,4 сая төг	БТГ: Зам, тээврийн салбарын хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тус яамны харьяа газар, байгууллагуудаас судалгаа авч нэгтгэн танилцуулж, яамны удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу "Зам тээврийн салбарын норматив, баримт бичгийн тогтолцоог боловсронгуй болгох сангийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө"-д судалгаа хийх, шаардлагатай норм боловсруулах ажилд 35.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Уг төлөвлөгөөний дагуу Зам, тээврийн салбарын хог хаягдлын менежментийн талаар судалгаа хийх, норм	40%

